

Фам хюй чяу (БНСВУ)

**ВЬЕТНАМЫН ХУА ЯСТАН БЭЭЖИНГИЙН  
ЭРХ БАРИГЧДЫН ҮНДЭСНИЙ ХАРГИС БОДЛОГОД  
ӨРТӨГДӨЖ БУЙ НЬ**

1. Вьетнам бол олон ястны улс. Вьетнамын үндэстний цөөнхийн тоонд хуа нар бас орно. Хуа нар гэдэг нь вьетнам дахь хятад хүмүүсийн ерөнхий нэр юм. Хуа нар барагцаалбал 1,1 сая орчим байгаа бөгөөд ихэнх нь хот суурин газар (Шолон хотод хамгийн их төвлөрсөн) оршин сууж байна. Бас үлэмж хэсэг нь Вьетнам-хятадын хилийн районд болон Вьетнамын баруун өмнөд районд оршин сууж байна.

Хуа нарын ихэнх нь хятадын феодал милитаристуудын дарлал мөлжлөгөөс зугадан амь зуухаар 200—350 жилийн тэртээгээс Вьетнамд нүүн ирж суурьшсан улс юм. Мөн Мин улс мөхөж Чин улс тогтох зааг дээр болон Тайпины бослого дарагдсаны дараа хятадын засгийн хатуу ширүүн залхаан цээрлүүлээс зугадан амь гарахын тулд ирсэн улс ч бий. Хожим АНУ-ын эсрэг дайны жилүүдэд Гонконг, Макао, Тайвань-аас хятад хүмүүс өмнөх Вьетнамд ирж худалдаа хийн тэндээ үлдэн суурьших явдал нилээд байв.

Эрт дээр цагаас Вьетнамд аж төрж ирсэн хуа нар вьетнам хүний нэгэн адил олон үеийн турш газрын эзэд, харийн колоничлогчид, милитаристуудад дарлагдан мөлжигдөж байв. Тэд вьетнамын үндэстний цөөнхийн нэгэн адил өөрийн гэсэн тухайн нутаг дэвсгэргүй энд тэнд хэсэг бусгаар аж төрж эдийн засгийн хувьд хэзээ ч бие даасан байдалтай байгаагүй юм. Гэвч тэд угсаатны харилцаа хийгээд өвөрмөц зан заншил, хэл, соёлоо өвлөн хадгалсаар ирэв. Вьетнамын хөдөө нутагт олон үеийн турш вьетнам хүмүүстэй хутгалдан аж төрж, үндэсний хэлээ мартсан буюу бага мэддэг хуа нар ч гэсэн хот суурин газар аж төрдөг бусад хуачуудтайгаа хэлхээ холбоотой байж тэдний нөлөөг байнга тусгаж байдаг юм.

Вьетнамд ирж хувийн ажил алба эрхлэн аж төрж байгаа хятад хүмүүс бие биенээ тэтгэн тусалж яваандаа өөр хоорондоо хэлхээ холбоо тогтоосон байна. Хувьсгалын өмнөөс эхлэн тэд уугуул нутгийнхаа нэрээр (Гуан дун, Хайнань, Хэ гэх мэт) нэрлэсэн «нутаг нэгтний нийгэмлэгүүд» зохион байгуулж байсан явдал тэдний үндсэрхэг сэтгэл зүйг улам дэвэргэж байв.

Хуа нарын ихэнх нь энгийн хөдөлмөрчид боловч нэг хэсэг нь харийн колоничлогч, хөрөнгөтнүүдэд түүхий эд нийлүүлж худалдаа хийдэг компрадор хөрөнгөтнүүд бөгөөд тэдний дотроос худалдааны хөрөнгөтнүүд олноор төрөн гарч байв. Өмнөд Вьетнамд америкчууд шинэ колоничлолын бодлого явуулж байх үед хуа нар өмнөд вьетнамын гадаад худалдааны капиталын 80%-ийг, эдийн засгийн үйл ажиллагааны 75%-ийг өөрийн хяналтанд оруулсан байна.

Харийн колоничлогчид болон худалдааны хөрөнгөтөн хуачууд хамтран хятад гаралтай хүмүүсийн (хуа нарын) сэтгэл зүйн сул талыг овжин ашиглаж, вьетнамын үндэсний хөрөнгөтөн төрж гарах явдалд хориг саад тавин хуачууд вьетнамчуудын хооронд хагарал гаргахад итгэлтэй

туслагч болгон ашиглаж байв. Тэд хуачуудын дунд мэргэжлийн болон нийгэм соёлын (эмнэлэг, сургууль, биеийн тамир г.м.) тусгай байгууллагуудыг дан хятад гаралтай хүмүүсээр эрхлүүлэн ажиллуулахыг дэмжиж байв. Тэгэхдээ худалдааны хөрөнгөтнүүд ёрийн хөдөлмөрчин хуа нарын үндэсний үзэл буюу «мах цусны холбоог» ашиглаж, хуа нарын ангийн ухамсрыг аль болохоор сарниулахыг эрмэлзэж байсан нь тэднийг амар хялбар мөлжин дарлаж байх гэсэн бодлоготой холбоотой байв.

2. ВКН-ын чиг шугам бол империализм, феодализмын эсрэг тэмцэлд улс орныхоо нийт үндэстнийг нягтруулахад чиглэгдэж байв. 1954 онд Вьетнамын умард хэсэг чөлөөлөгдөж социалист хувьсгалын шатанд шилжин орсон билээ. 1955 оны 6-р сард ВКН-ын Төв Хороо ХКН-ын Төв Хороотой дараах зүйлийг хэлэлцэн тохирсон юм. Үүнд: ВКН, Вьетнамын засгийн газар Вьетнам дахь хуачуудтай холбогдох бүх асуудлыг хариуцах бөгөөд вьетнам дахь хуачууд яваандаа БНАВУ-ын бүрэн эрхт иргэн болно гэж заасан юм. Энэ нь хуа нарын бодит байдлыг харгалзан үзэж социалист байгуулалтын объектив хуульд тулгуурласан заалт байлаа. Учир нь ангигүй нийгэмд ангийн зөрчил устахын хамт үндэстний зөрчил мөн устахын жамтай. Иймд энэ нь бас үндэстнүүд эрх тэгш байх зарчим болон марксизм-леннизмийн пролетарийн интернационализмын зарчимд нийцэж байгаа юм.

1958 онд Вьетнам дахь хятадын элчин сайдын яам хуа нартай холбогдол бүхий бүх байгууллага түүний дотор хуа нарын эрхлэсэн эмнэлэг, сургууль, сонины газар, олон нийтийн байгууллагыг хүртэл вьетнамын талд албан ёсоор хүлээлгэн өгсөн юм.

1960 онд умард вьетнамын үйлдвэр-худалдаа, гар үйлдвэр, хөдөө аж ахуйн салбарт социалист өөрчлөлт үндсэндээ шувтарч хөрөнгөтний ангийг устган хувийн аж ахуйг хамтын аж ахуй болгон хувиргасан явдал хуа нарын доторхи ангийн бүтцийг өөрчлөв. Энэ үеэс эхлэн хуа нар вьетнамын ард түмний нэгэн адил хамтын хөдөлмөрт гар бие оролцон Вьетнам орны тэгш эрхт эзэн болов. Социалист эдийн засгийн үндсэн дээр хуачууд, вьетнамчууд улам нэгдэн нягтарсан юм. Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын хувьд хуачууд вьетнам иргэдийн нэгэн адил бүхий л эрхийг эдлэх болов. Хуа нарын хувьд яваандаа сайн дурын үндсэн дээр вьетнамын харъяат иргэн болох боломж нөхцөл бий болсон бөгөөд үнэн хэрэгтээ вьетнамын иргэнээс ялгарахгүй болсон байв. 1961 онд Вьетнам дахь Хятадын Элчин сайдын яам мэдэгдэхдээ: үүнээс хойш хятадад байгаа төрөл төрөгсөдтэйгээ уулзахыг хүссэн хуа нарт хятадын тал паспорт олгохгүй бөгөөд тэд зөвхөн вьетнамын зөвшөөрлөөр явж байх болно. Хятадын Элчин сайдын яам тэдэнд зөвхөн нэвтрэх виз олгох үүргийг хүлээнэ» гэж мэдэгдсэн юм.

Гэвч 1962 оноос эхлэн Бээжингийн харгис бүлэглэлээс коммунист намуудтай харилцах харилцаанд хагарал гаргаж эхлэмэгц вьетнам дахь хуачуудын хүчийг төвлөрүүлж эхлэсэн бөгөөд өөрийн гар хөл болсон тагнуул төлөөлөгчдийг «Шинэ вьет-хуа» сонины газар, хуачуудын сургуулиуд, мөн вьетнамын эх орны фронтын доторхи хуачуудын байгууллага болох «Хуачуудын нийгэмлэг» зэрэг байгууллагуудад шургуулж тэднийг гартаа авсан юм. 1963 онд олон улсын коммунист хөдөлгөөнийг хагалан бутаргах хятадын үйл ажиллагаанд оролцохоос ВКН татгалзсан билээ. Иймд 1966 онд Вьетнам дахь Хятадын элчин сайдын яамаар дамжуулан соёлын хувьсгалыг вьетнамд экспортлохын тулд Мао Зэдүний үзэл санааг хуачуудын дунд сурталчлах үйл ажиллагааг Бээжингийн харгис бүлгийнхэн хүчтэй болгов. «Вьетнамд Мао Зэдүний үзэл санаагаар туслах нь эд материалын тусламжаас илүү чухал» хэмээн тэд сурталчилж байв. Хятадын засгийн газрын дэргэдэх цагаач иргэдийн асуудал эрхлэсэн комиссоос вьетнам дахь хятад гаралтай хүмүүст хандан «Хуацяо нарт их

гүрний үндсэрхэх үзэл заавал байх хэрэгтэй» гэж уриалсан бөгөөд тэд хятадын харъяат байх эрхээ алдсанд орвол толгойгоо, намаа алдсан дээр, хуацяо нарын бие вьетнамд, сэтгэл нь хятадад байх хэрэгтэй» гэх мэтээр сурталчлах болсон юм. Тэд нууц улаан хамгаалагчдыг зохион байгуулж, хуачуудын сургуулиудад «хувьсгалч багш, шавь нарын нийгэмлэг» гэгчийг байгуулж, хуачуудын ажилладаг үйлдвэр, завод, хөдөө аж ахуйн хоршоололд» Мао Зэдүний үзэл санаанаас суралцах бүлэг байгуулан ажиллуулав. Мөн Маогийн үзлийг сурталчлах ажлаа хүчтэй болгохын тулд сайн дурын уран сайханчдын дугуйланг хуа нарын дунд байгуулж байв. Тэд хуа нарыг төөрөлдүүлэн Вьетнамын Коммунист Нам, түүний засгийн газарт үл итгэх сэтгэл төрүүлэхийг хичээж орон нутгийн «бослого» (цзаофань)-д бүх хүчээр бэлтгэж байв.

Тэд вьетнам дахь хуачуудыг ашиглан шахалт даралт үзүүлж вьетнамын чиг шугамыг өөрчлүүлэх улс төрийн хүчин болгон ашиглахыг оролдов. Жанжлан ноёрхох энэ оролдлого нь ялагдалд учирсан боловч тэд одоо ч санаархлаа орхиогүй хэвээр байна.

3. Бээжингийн эрх баригчид аман дээрээ вьетнамыг дэмжиж байгаа мэтээр мэдэгдэж байсан боловч нууц тагнуул төлөөлөгчөө өмнөд вьетнамд нэвтрүүлж, хуачуудын дотор нууц байгууллагуудыг байгуулан удирдаж байснаас гадна Парисын хэлэлцээний заалтын дагуу америкийн тал цэргээ арга буюу татах үед 1974 оны 1-р сарын 19-нд Вьетнамын хуангша (Парасель) арлыг түрэмгийлэн эзлэсэн юм.

1975 онд Өмнөд Вьетнам чөлөөлөгдөж нэгдсэн вьетнам улс бий болов. Энэ явдал америкийн империализмтай хуйвалдаж байсан хятадын эрх баригчдын хүсэл зорилгод нийцсэнгүй. Иймд вьетнамыг эсэргүүцэхийн тулд нэг талаас Пол Потын харгис бүлгийг ашиглан вьетнамын эсрэг хилийн дайн дэгдээж, нөгөө талаас вьетнамын өмнөд хэсэг дэх өөрийн гар хөл бологчдод үймээн самуун дэгдээх тушаал буулгав. Вьетнамын өмнөд хэсэг дэх Бээжингийн гар хөл бологчид хуачуудын дотор суртал нэвтрүүлгийн «кампани дэгдээж» «үндсэрхэх үзлийг дэвэргэн», «хятадын харъяат болох хөдөлгөөн» гэгчийг өрнүүлэв. Тэд вьетнамын өмнөд хэсэг дэх эдийн засгийн социалист өөрчлөлтийн бодлогыг эсэргүүцэхийн тулд «Хуацяо-г аврах нийгэмлэг», «марксист-ленинист залуучуудын эвлэл», «эх оронч хуацяо окутан нарын нийгэмлэг» зэрэг байгууллагуудыг нууцаар байгуулав. Энэ үед Тайваний паспорттай хөрөнгөтөн хуацяо нарын зарим хэсэг Чан Кайшийн хөргийг яаран буулгаж оронд нь Маогийн зургийг дүүжлэхэд хүрсэн юм.

Ийм нөхцөл байдалд ВКН Өмнөд Вьетнам дахь хуачуудын харъяаллын асуудлыг хуучин хэвээр байлгах бодлогыг баримталсан бөгөөд энэ нь тус улсын хэмжээнд явуулж байгаа бодлогыг нэгтгэх шаардлагад тохирсон төдийгүй (хөдөлмөрчид зонхилсон) хуачуудын үндсэн эрх ашигт нийцсэн бодлого байв. Нөгөө талаар Өмнөд Вьетнамын эдийн засгийг социалист ёсоор яаралтай өөрчлөх, юуны өмнө капиталист үйлдвэр-худалдааг устгах зорилтыг манай намаас дэвшүүлсэн юм. «Улс орны доторхи үндэстнүүдийн эвдэршгүй эв нэгдлийг бэхжүүлэх, социалист вьетнамын үйл хэрэгт цөөнх үндэстнүүдийн хувьсгалт ухамсар, бүтээлч идэвхийг дайчлан өрнүүлэх явдал манай намын чиг шугам мөн гэж ВКН-ын IV их хурлын шийдвэрт заасан юм.

Гэвч Бээжингийн харгис бүлэг хуачуудыг ашиглах бодлогоо улам бүр идэвхжүүлсэн юм. ХКН-ын IX их хурлаас (1977) жанжлалын эсрэг (чухамдаа ЗХУ, дэлхийн социализмын эсрэг) нэгдсэн фронт байгуулахыг уриалсан бөгөөд энэ фронтын бүрэлдэхүүнд «3-р ертөнц», «2-р ертөнц» гэгчийг болон АНУ-ыг оролцуулахыг мэдэгдэв. Тэд бас эх газрын хятад, Тайваний хятад, хилийн чанад дахь хуацяо нар зэрэг гурван хүчнийг нэгтгэхийг хүсч байгаагаа мэдэгдэв.

Бээжингийн харгис бүлэг олон жилийн өмнөөс хилийн чанад дахь хуацяо нарыг валютын орлогын эх үүсвэр болгон ашиглаж ирэв. Тэд Гоминьданы үеийн бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн юм.

«Хуацяо-г ашиглан бусад орны ард түмнийг Бээжингийн эрх баригчид тойруу замаар мөлжиж байна» гэж зарим судлагчид оновчтой дүгнэн хэлсэн байна. Гадаадад байгаа хятад хөрөнгөтнүүдтэй эвсэн нэгдэх бодлогыг явуулахаа Бээжин саяхан дахин мэдэгдлээ.<sup>1</sup> Тэд хятад хөрөнгөтнүүд болон тэдний төрөл садныг онцгой эрх дархаар хангаж байна. Хятадын харьяат болон харьяат биш аливаа хятад гаралтай хүмүүсийг жанжлалын эсрэг нэгдсэн фронтын гадна орхиж болохгүй гэж хятадын засгийн газрын дэргэдэх цагаачдын асуудал эрхлэсэн хорооны дарга нууж хаалгүй мэдэгдсэн байна. Ингэхлээр хуацяо нар төдийгүй аль нэг улсын харьяат хятад гаралтай хүмүүс хүртэл цөм 5-р цуваанд багтаж Бээжингийн бодлогод туслах үүрэг гүйцэтгэх ёстой болж байна.

Өмнөд Вьетнам дахь хятад гаралтай хөрөнгөтнүүд зонхилсон хөрөнгөтний ангийн эдийн засагт өөрчлөлт хийх үед Бээжингийн эрх баригчдаас «хятадын харьяат нарыг хавчин хяхаж, хөөж тууж байна» гэж цуу тараасан явдал хэн бүхэнд ойлгомжтой юм. Урьдчилан тооцоолсон төлөвлөгөөний дагуу тэд Вьетнам дахь хуа нарын дунд хутган үймүүлсэн суртал нэвтрүүлэг дэгдээсэн юм. Тэд суртал нэвтрүүлэгтээ: «Вьетнамын эсрэг байлдаж байгаа Пол Потынхныг хятад улс дэмжиж байна. Хятад-Вьетнамын хооронд эрт орой хэзээ нэг цагт дайн гарна. Вьетнамд байгаа хуачууд хятад эх орондоо буцаж, улс орноо цогцлон байгуулахад гар бие оролцох хэрэгтэй. Вьетнамд үлдвэл эх орноосоо урвасанд тооцно» гэж айлган сүрдүүлэв. Үүний улмаас 1978 оны эхээр Вьетнамын умар хэсэг дэх олон арван мянган хуачууд Хятадад хууль бусаар гарсан юм.

1978 онд «хэлмэгдэгч цагаачдын» тухай жүжгийг бээжингийнхэн ийнхүү тоглосон явдал Вьетнамд улс төр, эдийн засгийн талаар бэрхшээл учруулах, тэрчлэн вьетнамын эсрэг түрэмгий дайн хийж байсан Пол Потын бүлэгт дэм үзүүлэх зорилготой байв. Пол Потын дэглэмд хэлмэгдэж Кампучаас Вьетнамд дүрвэж гарсан хятадын 26000 цагаач иргэдийн хувь заяанд тэд өчүүхэн ч сэтгэл өвдөхгүй мөртөө ийнхүү Вьетнам дахь хуачуудын эрх ашгийг хамгаалж байгаа дүр үзүүлсэн юм. Гэвч хятадын энэ жүжиглэл удалгүй тар нь танигдаж «вьетнамд хэлмэгдсэн» гэгдэж байгаа цагаачдаа хүртэл гаргуунд нь хаясан юм. Тухайлбал «хэлмэгдсэн цагаачдыг» угтан тосч байгаа тухай сүржин суртал нэвтрүүлгийг дэгдээснийхээ дараахан 1978 оны 7-р сарын 12-нд гэнэт хилээ хааж «хэлмэгдэгсдээ» угтан авахаа больсон юм.

Бээжингийн бүлгийнхний хорон санааны зорилго юу байсан бэ гэвэл «Вьетнам улс хятад гаралтай хүмүүсийг гадуурхаж байгаа мэтээр хятадын ард түмэнд ойлгуулж, улмаар хятадын ард түмний дунд үндэсний үзлийг дэврээн Вьетнамын эсрэг дайсагнасан ажиллагааг хүчтэй болгох зорилготой байв. Бээжингийн эрх баригчид 600 мянган цэргийг дайчлаи 1979 оны 2-р сарын 17-нд БНСВУ-ын эсрэг ичгүүр сонжуургүй түрэмгийлэл үйлдэв. Вьетнамаас урван гарсан олон тооны хуа нарыг энэ дайнд газарч, мэдээлэгчийн үүрэг гүйцэтгүүлэв. Үндсэрхэх бодлогод хөтлөгдсөн Бээжингийн эрх баригчид дайны үед цэргүүддээ «Хуа нарыг авар, нунг ястанд бүү гар хүр, нханг ястныг ашигла, кинь ястныг устга» хэмээн тушаал өгчээ. Вьетнамын эсрэг энэхүү зэвсэгт түрэмгийлэл нь хятад гаралтай хүмүүсийг ашиглах хятадын бодлогыг дээд зэргээр хэрэгжүүлсэн юм. Энэ түрэмгийлэл нь «хэрэв шахалт хавчилтаар буулган сөгдүүлж чадахгүй бол цэрэг зэвсгийн хүчээр хавсарган нэгтгэх» гэсэн агуулга бүхий Бээжингийн гадаад улс төрийн бодлогын шинэ үе шатыг то-

<sup>1</sup> «Жэньминь жибао» 1978. I. 4

дорхойлж байна. Тэд «Дорно зүгийн НАТО» гэж өөрсдийгөө нэрлэхээс татгалзахгүй байна. Энэ нь хятадын эрх баригчид Азид Америкийн империализмын үүрэг гүйцэтгэж тэр районд америкийн үлдээсэн хоосон зайг бөглөж байгаагаа хүлээн зөвшөөрсөн хэрэг юм.

Бээжингийн эрх баригчдын өдүүлсэн зэвсэгт түрэмгийлэл нь их гүрний жанжлан түрэмгийлэх санаархлаа хэрэгжүүлэхийн тулд тэдний зүгээс чадах бүхнээ хийхэд бэлэн байгааг харуулж байна. МАХН-ын Төв Хорооны V бүгд хурал дээр нөхөр Ю. Цэдэнбалын хэлсэнчлэн «Хятадтай хил залгаа оршдог ямар ч орон хятадын эрх баригчдын түрэмгий явууллагын бай болж болзошгүй» гэдгийг хятадын түрэмгийлэл тод харууллаа.

4. Бээжингийн эрх баригчдын үзэл суртлын үндэс нь их гүрний үндсэрхэг үзэл юм. Тэдний үндэстний бодлого бол харгис бодлого мөн. Тэд вьетнамд байгаа хуа нар Зүүн өмнөд Ази болон бусад орон дахь хуацяо, хятад гаралтай хүмүүсийг их гүрний жанжлан түрэмгийлэх бодлогодоо зэвсэг болгон ашиглаж байна. Вьетнам дахь хуачуудын амар төвшин, хэвийн амьдралыг эвдэн бусниулсан явдал ч мөн үүнтэй холбоотой юм.

Үндэстний цөөнх хуа нарыг вьетнамын эсрэг өдөөн хатгаснаараа үндэстнүүдийн нэгдэл нягтралыг хатгадаг социализмын мөн чанарыг Бээжингийнхэн сөрж байгаа юм. «Үндэстнүүдийн бүхий л ялгаварлалыг устгаж, үндэстнүүдийг зааглагч хана хэрмийг эвдэхэд туслах аливаа ажлыг, тэрчлэн үндэстнүүдийн хэлхээ холбоог байнга бэхжүүлэхэд тус болох аливаа зүйлийг пролетарийн анги талархан дэмжиж байдаг»<sup>1</sup> Тэгвэл хятадын эрх баригчид үндэстний асуудал дахь пролетари ангийн эрх ашиг, байр суурийг бүрмөсөн таягдан хаясан байна.

Бээжингийн харгис бүлгээс үндэстнүүдийг хагалан бутаргаж хуачуудыг Вьетнам дахь кинь (вьетнамын голлох үндэстэн) болон бусад үндэстний эсрэг сөргүүлэн тавьж, Вьетнамыг Лаос, Кампучитай харгалдуулан дайсагнуулах бодлогыг идэвхтэй явуулж байна. Тэрчлэн бүх улс түмнүүдийн дотор үндэстний зөрчлийг дэвэргэж хувьсгалт хөдөлгөөнүүд дэх үндсэрхэх үзлийн үлдэгдлийг тэтгэн өөгшүүлж байна. «Жанжлан захирахын тулд хагалан бутаргадаг» империалистуудын уламжлалт бодлогоос хятадын эрх баригчдын бодлого ялгарах юм алга байна.

Их гүрний эзлэн түрэмгийлэх бодлогоо хэрэгжүүлэхэд Бээжингийн эрх баригчид үндэстний үзэл, тэр ч байтугай арьсны үзлийг (расизм) ашиглаж, байхад өнөөгийн империалистууд дэлхийн коммунист хөдөлгөөн, дэлхийн социализмыг задлан бутаргахын тулд Бээжингийн эрх баригчдын болон бусад оппортунист бүлгийн үндсэрхэх үзэлд асар их найдлага тавьж байна. Тийм ч учраас Бээжингийнхэн империализмын харгис отряд болон хувирч дэлхийн хувьсгалд ноцтой хор учруулж байна.

Хөрөнгөтний нэгэн сэтгүүлч Энэтхэг-хятадын хойгийн өнөөгийн байдлын тухай бичихдээ: «Энэтхэг-хятадын хойгоос АНУ цэргээ татаж, тус хойгт коммунистуудын үзэл дэлгэрсэн хийгээд Бээжингийн прагматикууд ялсан зэрэг үйл явдлууд 3 жил хүрэхгүй хугацаанд Азийн улс төрийн зургийг донсолгож мөргөлдөөний талбар болгов. Үүний нэг шалтгаан нь аливаа үндэстний түүхэнд мөнхийн дагуул бологч үндэстний үзэл нь (национализм) үзэл суртлын тогтолцоог эвдсэнд оршино»<sup>2</sup> гэжээ.

Энэтхэг-хятадын хойгт гарсан өнөөгийн мөргөлдөөний уг үндэс нь үндэстний үзэл гэгчийг бид хүлээн зөвшөөрч байгаа боловч тэрхүү үндэстний үзэл нь Бээжингийн эрх баригчдын жижиг хөрөнгөтний үндсэрхэх харгис үзэл гэдгийг хэлэх хэрэгтэй. Үүнээс гадна коммунистууд, интернационалчид бид «үндэстний үзэл бол аливаа улс үндэстний түүхийн мөнхийн дагуул» гэж үзэхийг үл зөвшөөрнө. Октябрийн хувьсгалаас эх авсан

<sup>1</sup> В. И. Ленин. Критические заметки по национальным вопросам (1913).

<sup>2</sup>Paul siquad, "Le Figaro" 1978. X.21

дэлхийн социалист систем бий болсон тэр үеэс хойш үндэстнүүдийн дунд шинэ харилцаа тогтсон юм. Тэр бол социалист үндэстнүүдийн хамтран ажиллаж, харилцан туслалцах шинэ маягийн харилцаа бөгөөд социалист үндэстнүүд бусад үндэстнүүдийн хооронд тогтсон тэгш эрхт найрсаг харилцаа юм. Бээжингийн харгис бүлэг үндэстний харгис үзлийг баримталснаараа социализмаас урваж, үндэстний асуудлаархи марксизм-ленинизмийн зарчмыг таягдан хаясан юм. Тийм учраас хятадын ард түмний өөрсдийн ч үндсэн эрх ашигт харшилж байна.

**Фам Хюй Чяу**

**ЭТНИЧЕСКАЯ ГРУППА ХУА ВО ВЬЕТНАМЕ-ИНСТРУМЕНТ  
И ЖЕРТВА РЕАКЦИОННОЙ НАЦИОНАЛЬНОЙ  
ПОЛИТИКИ ПЕКИНСКИХ ПРАВИТЕЛЕЙ**

**Р е з ю м е**

Автор статьи анализирует социально-экономическое положение хуа раскрывает их роль в политике пекинских руководителей, в осуществлении их великодержавных устремлений.

Хуа—это лица китайского происхождения (хуацяо), проживающие во Вьетнаме. Большинство хуа покинули родину 200—300 лет тому назад. Одни переселялись во Вьетнам, спасаясь от преследований китайских правителей, жестокости и эксплуатации китайских феодалов и милитаристов, другие—в период длительной гражданской и освободительной войн. Несмотря на то, что хуа давно проживают во Вьетнаме, они сохранили свои этнические, родственные и экономические связи. Для хуа во Вьетнаме создавались «землячества» (китайские общины), которые с давних времен укрепляли у хуа психоз «кровной связи» и великоханьского национализма, который впоследствии стал подчеркиваться Пекином в целях использования зарубежных китайцев в осуществлении своего великодержавного курса и оказании давления на страны, где проживают хуацяо.

Положение хуа особенно улучшилось в 1960 г., когда в Северном Вьетнаме, освобожденном в 1954 г., были в основном осуществлены социалистические преобразования в промышленности, торговле, кустарных предприятиях и сельском хозяйстве. Хуа, как граждане свободного Вьетнама, стали пользоваться всеми гражданскими правами во всех областях, для них были созданы условия для постепенного изменения их гражданской принадлежности, фактически они стали полноправными гражданами Вьетнама.

В 1962 г., когда руководство КПК порвало со странами социалистического содружества и пыталось нанести раскол международному коммунистическому движению, Пекин начал оказывать давление на хуа, делая из них своих агентов в различных организациях и учреждениях Вьетнама. А в период «культурной революции» реакционная пекинская группировка развернула среди хуа бурную деятельность антивьетнамского характера.

В 1975 г., когда была создана единая Социалистическая Республика Вьетнам, пекинское руководство еще более активизировало свои дейст-

вия в отношении хуа. Пекинские агенты, находящиеся среди хуа, вели ожесточенную пропаганду по разжиганию национализма, раздували у них психоз «кровной связи», требовали к возврату китайского гражданства. В таких условиях Коммунистическая Партия Вьетнама вынуждена была проводить политику сохранения статус-кво по отношению гражданской принадлежности хуа, что отражала чаяния и надежды прежде всего самих хуа. Создав «объединенный фронт для борьбы с гегемонизмом», пекинское руководство стремится вовлечь в него и зарубежных китайцев, в том числе хуа.

Пекин использует зарубежных китайцев не только в качестве политического оружия давления на политику стран, где они проживают, но и как источник поступления иностранной валюты. Хуа были использованы Пекином для разыгрывания «сцены» пострадавших хуацяо с тем, что искусственно создать трудности в экономическом строительстве социалистического Вьетнама, вмешаться в его внутренние дела.

Автор особо подчеркивает, что определенная роль была отведена Пекином хуа в подготовке вооруженной агрессии против Вьетнама и во время агрессии их использовали в качестве агентов и проводников. Как пишет автор, эта антивьетнамская вооруженная агрессия явилась кульминационным пунктом в политике Китая по использованию лиц китайского происхождения, по разжиганию национализма, расизма в целях экспансионизма и гегемонизма.

В заключение автор отмечает, что китайские руководители для осуществления своей великодержавной, агрессивной политики используют национализм, для которых он является якобы вечным константом истории всех наций. Однако, несостоятельность шовинистических концепций пекинских лидеров и обреченность всякого великодержавно-ханьского гегемонизма очевидны.